



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 02 өдөр

Дугаар А/166

Эрдэнэт

Г Тусгаарлах эмнэлгүүдийг ажиллуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.2, 32 дугаар зүйлийн 32.1, Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, Эрүүл мэндийн Сайдын 2021 оны "Түр заавар шинэчлэн батлах тухай" А/29 дүгээр тушаал, 2021 оны "Коронавируст халдвар (Ковид-19) оношилгоо, эмчилгээний түр заавар шинэчлэн батлах тухай" А/140 дүгээр тушаал, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны "Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд Коронавируст халдвар (Ковид-19) 2021 оны 03 дугаар сарын 24-ний өдөр илэрч батлагдсан тохиолдол нэмэгдэж, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн бэлтгэсэн орны нөөц хүрэлцэхгүй болсон тул нэмэлтээр тусгаарлах эмнэлгээр ашиглах байгууллагуудын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.Тусгаарлах эмнэлгүүдийн ажиллах стандарт, техник хэрэгсэл, хүний нөөц, эм, тарианы нөөцийг бэлтгэх, арга зүйн зөвлөмжөөр хангах, харуул хамгаалалт, аюулгүй байдлыг хангах, орчин нөхцөлийг бүрдүүлж зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Онцгой байдлын газар (Г.Ганбаатар), Цагдаагийн газар (С.Цэрэнсамбуу), Эрүүл мэндийн газар (Д.Сүхээ), Мэргэжлийн хяналтын газар (Б.Жигдэнгомбо), Бүсийн оношилгоо эмчилгээний төв (Б.Батсүх), "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ (Х.Бадамсүрэн)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж, тайлагнахыг аймгийн Засаг даргын орлогч А.Түвшинжаргал, М.Түмэнжаргал, Онцгой байдлын газрын дарга, хурандаа Г.Ганбаатар нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.БАТЖАРГАЛ

D:(Zahiramj) A-4 doc

6121020773

Аймгийн Засаг даргын 2021 оны 04
дүгээр сарын 02-ны өдрийн А/166
дугаар захирамжийн хавсралт

ТУСГААРЛАХ ЭМНЭЛГЭЭР АШИГЛАХ БАЙГУУЛЛАГУУДЫН ЖАГСААЛТ

Д/д	Байгууллагын нэр	Орны тоо	Зориулалт
1	Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Халдвартын тасаг	40	Тусгаарлах эмнэлэг
2	Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Мэдрэлийн тасаг	30	Тусгаарлах эмнэлэг
3	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Эмнэлэг сувиллын цогцолбор	100	Тусгаарлах эмнэлэг
4	Очир-Увидас хувийн хэвшлийн эмнэлэг	40	Тусгаарлах эмнэлэг
5	Ачит хувийн хэвшлийн эмнэлэг	40	Тусгаарлах эмнэлэг
Нийт		250	5

00